



ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН
11 ДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ НИЙГЭМ СУДЛАЛЫН СОНГОХ ХИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024.06.07

Хугацаа 80 минут

А хувилбар

Хэрлэн сум

Нийт оноо: 100

Сонгох даалгавар 30, оноо 60

Задгай даалгавар 10, оноо 40

Анги:

Сурагчийн нэр:

Сэргээн санах түвшний даалгавар

1. Нийгмийн гишүүдийг эрүүл мэндийн үйлчилгээ авах үйлээр нь :

1- дэх ангид эдийн засаг, санхүүгийн хувьд амжилттай байгаа

2- дахь ангид цалингаараа амьдардаг дундаж хэсгийнхнийг

3- дахь ангид ур чадвараараа бага, даржин амьдралтай хэмээн хуваан судалсан судлаач хэн бэ? /2 оноо/

А. Ө.Күүс В. Д.Датон С. Гилберт D. Калл

2. Соёлын адилсал гэдэг ойлголт соёл судлалд хэдийгээс хэрэглэгдэж эхэлсэн бэ? /2 оноо/

А. 1970-аад оны II хагас В. 1980-аад оны II хагас С. 1990 оноос D. 1990 оны

эхнээс

3. Мөнгөний тэлэх бодлого аль нь вэ? /2 оноо/

А. Гүйлгээнээс мөнгө татах буюу мөнгөний нийлүүлэлтийг бууруулах бодлого

В. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлого

С. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлого

D. Гүйлгээнд мөнгө нэмж оруулах буюу мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бодлого

4. "Иргэний нийгэм нь төрөөс үл хамаарах өөр хоорондын харилцаа, эрх зүйгээр зохицуулагддаг хувь хүмүүс, анги бүлэг, институтуудын нийлбэр цогц юм." гэж хэн үзсэн бэ? /2 оноо/

А. Р. Даредорьф В. Р.Путнам С. Г. Гегель D. М. Кинг

5. Эрүүгийн хуулиас бусад хууль зөрчсөн гэм буруутай үйлдэл, эс үйлдлийг юу гэж нэрлэдэг вэ?/2 оноо/

А. эрх зүй С. эрх зүйн зөрчил В. гэмт хэргийн зөрчил D. гэмт хэргийн бус

зөрчил

6. Хэрэг үүсгэх өдрөөс хойш нийслэлд хэд хоногийн дотор шүүх нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах вэ?

А. 7 хоног В. 14 хоног С. 21 хоног D. 30 хоног

7. Засгийн газрын оролцоо дэмжлэггүйгээр улс, үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг глобал түвшний оролцогчид, тоглогчид, олон улсын байгууллагыг юу гэж нэрлэдэг вэ? /2 оноо/

А. олон улсын харилцаа С. олон улсын эрх зүй

В. улс бус оролцогч D. гуравдагч хөршийн бодлого

8. Олон улсын байгууллагын үйл ажиллагааны глобал түвшинд аль нь хамаарах вэ? /2 оноо/

А. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн

В. Ази Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга

С. Аль Кайда бүлэглэл

D. Евразийн эдийн засгийн холбоо

Ойлгох түвшний даалгавар:

9. Энхбат төрсөн нутагтаа физикийн багшаар ажиллаж байгаад 5 жилийн дараа сургуулийн захирлаар томилогджээ. Энэ нь нийгмийн шилжих хөдөлгөөний аль хэлбэрт хамаарах вэ? /2 оноо/

А.Бүлгийн шилжих хөдөлгөөн

В.Үеийн хоорондын шилжих хөдөлгөөн

С.Үе дотоодын шилжих хөдөлгөөн

D.Хэвтээ чиглэлийн шилжих хөдөлгөөн

10. 1989 онд судлаач Мери Месенжер Девиес "Зурагт хүүхдэд сайн зүйл үү" гэдэг номондоо зурагтаар үзүүлдэг балмад явдлууд хүүхдүүдэд ямар нөлөө үзүүлдгийг анхааран судалжээ. Энд цочирдох, цагаатгах, мэдрэмжгүй болох гэсэн гурван янзын зөрчлийн тухай өгүүлжээ.1960аад оны сүүлч, 1970-аад оны эхээр Америкчууд бараг орой бүр зурагтын мэдээгээр биет аллагын үйлдлийг үзэх болж, өмнө нь огт үзүүлж байгаагүй аргаар

Вьетнамын дайныг үзүүлжээ. Америкчууд цэргүүдийн зовлонг үзээд жигшил зэвүүцэл төрж, улмаар Америкийн цэргийг дайнаас татаж авахад хүргэжээ.Энэ нь: /2 оноо/

А.Цочирдол В.Цэрвэх С.Хэт мэдрэмтгий болох D.Кибер орон зай

11. Төр татвараас гадна тодорхой төрлийн барааны импортод хязгаарлалт буюу квот тогтоож өгөх тохиолдол байдаг. Жишээ нь : Тухайн оронд жилд орох барааны тоо хэмжээг 20 мянган ширхэгээс, 100 сая төгрөгөөс хэтрүүлэхгүй байх гэх мэт. Ийм арга хэмжээг гадаад худалдааны ямар бодлого гэж нэрлэдэг вэ? /2 оноо/

А.Капиталын бодлого В.Демпинг
С.Санхүү мөнгөний бодлого D.Хөрөнгө оруулалтын бодлого

12. Хэрвээ төр өөрийн хөрөнгөөр нийтийн шинжтэй ажил, тухайлбал зам гүүр, бусад объектуудыг барьж байгуулснаар олон тооны хүмүүс ажилтай болж, тэдний орлого нь нэмэгдэж, улмаар нийт эрэлт нэмэгддэг гэвэл энэ нь: /2 оноо/

А.Төсвийн зарлагыг нэмэгдүүлэх бодлого В.Төсвийн орлогыг бууруулах бодлого
С.Зээлийн хүүгийн бодлого D.Татварын хэмжээг бууруулах бодлого

13. “Хоёр нам эсвэл зонхилох нэг намын тогтолцоо бий болох чиглэлд үйлчилдэг, шинээр гарч ирж буй болон жижиг намд ашиггүй, нутгийн хүнийг сонгох сэтгэл зүйн хандлага ихтэй, сонгогчдын санал гээгддэг” зэрэг нь сонгуулийн аль тогтолцооны шинжүүд вэ? /2 оноо/

А. Мажоритар тогтолцоо В. Пропорциональ тогтолцоо
С. Холимог тогтолцоо D. Хувь тэнцүүлэх тогтолцоо

14. Улс төрийн системийн гадаад шаардлага аль нь вэ? /2 оноо/

А. Ерөнхий сайдыг огцруулах В.Цалин тэтгэврийг нэмэх
С. Сонгуулийн хуулийг өөрчлөх D.Үндсэн хуульд өөрчлөлт оруулах

15. Тодорхойлолтуудаас аль нь хүндэтгэх үүрэг вэ? /2 оноо/

А. Тухайн эрхийг эдлэхэд ямар нэгэн саад учруулахгүй, зөрчихгүй байх үүрэг хүлээдэг
В. Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь сэргээх үүрэг

хүлээдэг

С. Хүний эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн баталгааг бий болгох арга замыг авах үүрэг

хүлээдэг

D. Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон хохирлыг арилгах бүтэц, тогтолцоог бий

болгох боловсронгуй хууль тогтоомж батлах үүрэг хүлээдэг

16. Тухайн захиргааны байгууллагыг байгуулах, татан буулгах, албан тушаалтныг сонгох, томилох, захиргааны актыг хүчингүй болгох эрх бүхий субъектыг “шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан”гэдэг. Тэгвэл дүүргийн Засаг даргын шууд харьяалах дээд тушаалтан хэн бэ? /2 оноо/

А.Ерөнхий сайд В.Нийслэлийн Засаг дарга С.Ерөнхийлөгч D.УИХ-ын дарга

17. ОУХ-ны тоглогчид нь бүрэн эрхт улс, тэдгээрийн холбоо, хамаахал эвсэл байна. Энэ нь олон улсын онолын аль чиглэлд хамаарах вэ? /2 оноо/

А. Неореалист онол В. Неолиберал онол С.Реалист D. Либерал

18. Монгол дэлхийн 164 улстай дипломат харилцаатай байна. Тэгвэл 1990 онд аль улстай дипломат харилцаа тогтоосон бэ? /2 оноо/

А.Бүгд Найрамдах Солонгос улс В.Бүгд Найрамдах Турк улс С .АНУ D. Канад улс

Хэрэглэх түвшний даалгавар:

19. Судалгааны явцад бичвэр мэдээлэл дэх бүх мэдээллийг кодлох үйлдэл хийж болно. Жишээ нь: 2002 онд төрсөн. Энэ нь доорх өгөгдлийн алинд нь хамаарах вэ? /2 оноо /

А. Нээлттэй кодлолт В. Хаалттай кодлолт С. Категорчлол D. Харьцуулсан жишилт

20. Монгол улсын эдийн засаг 2011 онд 17.5, 2012 онд 12.3 хувиар эрчимтэй өсөж байна. Харин ядуурлын хамрах хүрээ 2011 онд 9.4, 2012 онд 2.4 хувиар буурчээ. Тухайн жилүүдэд эдийн засгийн өсөлт хоёр оронтой тоогоор эрчимтэй өсөж байсан ч өсөлтийн үр ашиг ядуурлыг дорвитойгоор буурахад нөлөө багатай байсны учир шалтгааныг аль дүгнэлт хамгийн оновчтой тайлбарласан байна вэ? /2 оноо /

А. Эдийн засгийн өсөлтийг дагаж, ядуурал буурсантай холбоотой.
В. Эдийн засаг өссөн ч, тэгш бус байдал өссөнтэй холбоотой.
С. Эдийн засгийн өсөлт ядуурлыг бууруулаагүй байна.
D. Эдийн засгийн өсөлттэй ядуурлын бууралт холбогдох албагүй.

21. Хүснэгтийн хоосон зайд тохирох өгөгдлүүдийг зөв байршуулна уу. /2 оноо/

Өгөгдлүүд: /1-Иргэдийн авьяасыг нээх, хөгжүүлэх боломжийг бий болгох; 2-Түүх, соёлын үнэт зүйлийг нийтийн хүртээл болгох; 3-Соёлын аялал жуулчлалын ач холбогдол/

Соёлын үйлдвэрлэлийн ач холбогдол	A
B	Бусдын соёлд хүндэтгэлтэй хандах
Ажлын байр нэмэгдэх	C.....

A. a3,b1,c2

B. a3,b2,c1

C. a2,b3,c1

D. a2,b1,c3

22. Хувь хүн болон бүлгийн аж төрөх хэв маягаа сонгох нөхцөл, боломжийг хязгаарлаж, нийгмийн бусад гишүүдийн адилаар амьдрахыг шаардлага болгох нь соёлын эрх чөлөөг зөрчих хандлагын аль нь вэ? /2 оноо/
- A. Нийгмийн амьдрал дахь оролцоог хязгаарлах
B. Амьдралын хэв маягийг үгүйсгэх
C. Иргэдийн соёлыг оролцуулан бүх соёлыг ижил тэгш үнэлж, хүндэтгэх
D. Хувь хүний сонголт хийх бололцоог өргөжүүлэх
23. Манай улсын ГШХО-ын 70,0 орчим хувийг уул уурхайн салбар дахь ГШХО эзэлдэг. Уул уурхайн салбар дахь ГШХО нь түүнийг оруулж ирж буй улсдаа сөрөг үр дагавартай вэ?
- A. Улсын төсвийн орлогын ихээхэн хувийг уул уурхайн салбараас бүрдүүлдэг
B. Гадаадын уул уурхайн компанид манай улсын олон мянган хүн ажил эрхэлж байна
C. Уул уурхайгаас хамаарсан эдийн засгийн өсөлт иргэдийн амьжиргаанд нөлөө үзүүлэхгүй байна.
D. Дотоодын үндэсний үйлдвэрлэгчид гадны компанийн ашиглаж буй технологийг хуулах замаар бүтээмжийг өсгөх боломжтой.
24. Японы цахилгаан бараа, автомашин эсвэл Герман гутал, Франц үнэртэй ус зэрэг нь хэрэглэгчдийн сайн сайхан аж байдалд нөлөөлнө". Дээрх жишээ нь гадаад худалдааны аль онолд хамаарах вэ?/2оноо/
- A. Харьцангуй давуу тал
B. Туйлын давуу тал
C.Гадаад худалдааны тэнцэл
D.Демпинг худалдаа
25. Дараах бүдүүвчид өгсөн өгөгдлүүдийг зөв дараалалд оруулна уу. /2 оноо/
Өгөгдлүүд: /1-Гомдол хүлээн авах бүртгэх, 2-Гомдлын мөрөөр шалгалт хийх, 3- Гомдлыг шийдвэрлэх, 4-Гомдлыг шийдвэрлэх үйл явц/



- A. a4,b1,c3,d2 B. a4,b1,c2,d3 C. a1,b2,c3,d4 D. a1,b2,c4,d3
26. Хүний эрхийн үндэсний Комисст гомдол гаргахад тавигддаг шаардлагуудаас илүүцийг ол.
- A. Гомдлоо захиргааны журмаар шийдвэрлүүлсэн байх
B. Өөрийн нэр, оршин суугаа газрын болон шуудангийн хаяг, утасны дугаараа бичиж гарын үсэг зурсан байх
C. Гомдолд холбогдож буй аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүний нэр, хаяг, утасны дугаар холбогдох бусад баримтыг хавсаргах
D. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, эсвэл чөлөөлөгдөх хүсэлт, түүнийг нотлох баримт байх
27. Монгол улсын иргэн Батаа 2016 оны УИХ-ын сонгуульд ардчилсан нам болон ардчилсан намаас нэр дэвшсэн Жаргалын төлөө саналаа сонгуульд өгчээ. Энэ нь: /2 оноо /
- A. Оролцооны дэмжлэг B. Бодит дэмжлэг C. Гадаад шаардлага D. Дотоод шаардлага
28. Улс төрийн намын онцлог шинжид аль нь хамаарах вэ? /2 оноо /
- A. Мэдээллийг хянаж дүн шинжилгээ хийх
B. Бодлогоо хэрэгжүүлэхдээ алдаа гаргах, биелэлтийг нь бүрэн хангаж чадахгүй бол улс төрийн хариуцлага хүлээх чадвартай байх
C. Ямар нэгэн асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд нам эрх бүхий албан тушаалтанд сонгуулийн болоод бусад үед санхүүгийн дэмжлэг үзүүлэх эсвэл үзүүлэхгүй гэдгээ илэрхийлэх
D. Асуудлаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж, ард түмний дэмжлэгийг авсны үндсэн дээр парламентаар хялбахан шийдвэрлүүлэх
29. Монгол улстай түншлэлийн харилцаатай улсуудыг харуулсан бүдүүвчийг гүйцээгээрэй. /2 оноо/
- а)..... : ОХУ, б)....., Япон
- A.а-Стратегийн түншлэл, б-Энэтхэг
B.а-Иж бүрэн стратегийн түншлэл, б-БНХАУ
C.а-Стратегийн түншлэл, б-БНСУ
D.а-Иж бүрэн түншлэл, б-АНУ
30. Зөөлөн хүчний бодлогыг оновчтой хэрэгжүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газрын 2016 оны 2-тогтоолд Монгол улсыг гадаадад сурталчлах хөтөлбөрт 4 чиглэлийг тэргүүлнэ хэмээн заасан. Тэргүүлэх чиглэлд хамааралгүй хэсгийг сонгоно уу. /2 оноо /
- A. Түүх, соёл, урлаг B. Аялал жуулчлал
C. Үндэсний брэнд, бараа бүтээгдэхүүн үйлчилгээ D. Эдийн засаг

Задлан шинжлэх түвшний даалгавар:

31. Тохиолдлыг уншаад асуултын дагуу шинжлээрэй.

Тохиодол 1.Иргэн Э нь 1978 онд Улаанбаатар хотод жолооч Б-ийн гэр бүлд төрсөн. 1996 онд арван жилийн сургуулиа төгссөн. 2000 онд МУИС-ийг судлаач мэргэжлээр төгсөөд ЕБС-ийн сургуульд багшилж байгаад 2008 онд Удирдлагын академийг нийгмийн удирдлагын мэргэжлээр төгсч, боловсролын хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллах болсон.

Асуулт: Тохиолдол байр суурийн хөдөлгөөний ямар чиглэлд хамаарах вэ?

Асуулт. Босоо ба хэвтээ чиглэлийн байр суурийн хөдөлгөөний ижил ба ялгаатай талыг харьцуулна уу.

--	--

32. Хүснэгтийн хоосон зайд тохирох өгөгдлийг зөв байршуулна уу. /4 оноо/

Өгөгдөл: /1-Соёлын орон зай; 2-Соёлын аялал жуулчлал; 3-Соёлын даяаршил; 4-Соёлын шок; 5-Соёлын дархлаа; 6-Соёлын адилсал/

А.....	Соёлынх нь өвөрмөц байдал болон бусдаас ялгаран онцгойрох хэв маягт гаднын нөлөө орж өөрчлөгдөх, эсвэл соёлын тулгалтаар устгах оролдлого гарах тохиолдол бүрд хариу үзүүлэх чадвар
В.....	Ард түмэн өөрийн соёлын хэм хэмжээ, зан үйл, хэл, үнэлэмжийн баримжааллыг ухаарч ойлгох, тэрхүү соёлын байр сууринаас өөрийгөө ойлгох, тэрхүү соёлыг тээгч гэдгээ ухаарах байдал
С.....	Өөр соёлын орчин нөхцөл тухайн хүний хүссэнээс огт өөр байх, бүтэлгүйтэх, сэтгэл ханамж мэдрэгдэхгүй байх үед үүсэх бухимдал, гутрал, түгшүүр гэх мэт сөрөг мэдрэмж үүсэх үеийн сэтгэл зүйн байдал
Д.....	Зам харилцаа, эдийн засгийн харилцаа, мэдээлэл харилцааны хөгжлийн үндсэн дээр тусгаар соёлууд дэлхийн нэгдмэл соёлд нэгдэн нийлэх үйл явцыг хэлнэ.

33. Доорх хүснэгтэн мэдээллийг ашиглан 33,34-р асуултад хариулаарай.

Монгол улсын гадаад худалдааны ашиг хэдэн онд хамгийн их байсныг тооцоолно уу. /4 оноо/

Монгол улсын гадаад худалдаа, сая ам.доллар				
Үзүүлэлт	2010	2012	2014	2016
Нийт эргэлт				
Нийт экспорт	2908.5	4384.7	5774.3	4916.3
Нийт импорт	3200.1	6738.4	5236.7	3358.1
Гадаад худалдааны +ашиг (-алдагдал)	?	?	?	?

Бодолт хийх:

A.2010 B.2012 C.2014 D.2016

34. Доорх хүснэгтэн мэдээллийг ашиглан Монгол улсын гадаад худалдааны ашгийн хэмжээг /алдагдлын хэмжээг/ хэрхэн тодорхойлох вэ? /4 оноо/

Бодолт хийх:

35. Дараах тохиолдлыг уншаад 35,36 дугаар асуултад хариулаарай.

Тохиолдол: Авто тээврийн хэрэгслийн хулгай 2018 онд 2009 оноос 4.5 дахин, 2014 оноос 73.1%, 2017 оноос 16.8 %-иар нэмэгдсэн байна. Халаасны хулгай 2018 онд улсын

хэмжээгээр 1276 бүртгэгдсэн нь өмнөх оноос 421 (49.2%)-ээр өссөн байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн 1276 халаасны хулгайн 1269 (99.5%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.
Асуулт: Гэмт хэргийн гол шинжийг нэрлэнэ үү? /4 оноо/

.....
.....
.....

36. Дээрх тоон мэдээллийг уншаад ямар дүгнэлт хийж болох вэ? /4 оноо/

37. Дараах баримтыг судлан 37, 38-р асуултад дүн шинжилгээ хийнэ үү.

Баримт 1. 1992 оны УИХ-ын сонгуульд МАХН /одоогийн МАН/ нийт сонгогчдын 53%-ийн санал авсан ч парламентын суудлын 92.1 хувь буюу 70-ыг авч байсан бол бусад нам эвслүүд нийт сонгогчдын 47 хувийн санал авсан хэдий ч парламентад 6 суудал авч байсан.

Баримт 2. 2000 оны УИХ-ын сонгуульд МАХН /одоогийн МАН/ нийт сонгогчдын 52 хувийн санал авсан ч парламентын суудлын 94.7 хувь буюу 72-ыг авч байсан бол бусад нам эвслүүд нийт сонгогчдын 48 хувийн санал авсан хэдий ч парламентад 4 суудал авч байжээ.

Баримт 3. 2016 оны УИХ-ын сонгуульд МАН нийт сонгогчдын 45.69 хувийн санал авсан ч парламентын суудлын 85.5 хувь буюу 65-ыг авч байсан бол бусад нам эвслүүд нийт сонгогчдын 54.31 хувийн санал авсан хэдий ч парламентад 11 суудал авч байжээ.

Дүн шинжилгээ хийнэ үү:

Энэ 3 баримт сонгуулийн ямар тогтолцооны онцлогийг харуулж байна вэ? /4 оноо/

.....
.....
.....

38. Сонгогчдын саналыг их авсан ч парламентын суудал бага авч байгаа шалтгааныг тайлбарлана уу. /4 оноо/

.....
.....
.....

Дараах мэдээллийг уншаад 39,40-р асуултад хариулаарай

Мэдээлэл 1. Америкийн мэргэжлийн сагсан бөмбөгийн од, "ахмад" тамирчин Деннис Родман дэлхий нийтийн анхаарлын төвд эргэн ирээд багагүй хугацаа өнгөрч байна. Өдгөө 54 настай, хэдийнээ зодог тайлсан тэрээр энэ удаа уран гоё тоглолтоор биш, АНУ-ын түүхэн дайсан, дэлхийн хамгийн хаалттай улс гэгддэг Хойд Солонгосын дарангуйлагч хэмээн цоллуулаад буй залуу удирдагч Ким Чен Ун болон түүний гэр бүлийнхэнтэй биечлэн уулзаад зогсохгүй, дотно нөхөрлөж чадсан цорын ганц америк хүн гэдгээрээ анхаарал татаад байгаа билээ. Албан ёсны баримтаар Деннис Родман Хойд Солонгост хэд хэдэн удаа айлчилж, тус улсын үндэсний сагсан бөмбөгийн шигшээ багтай "Пхеньян дахь том тэсрэлт" нэртэй нөхөрсөг тоглолт зохион байгуулж байсан билээ.

39. Асуулт: Деннис Родман олон улсын харилцааны оролцогч мөн эсэхийг тайлбарлан бичнэ үү.

.....
.....
.....

40. Олон улсын харилцааны улс бус оролцогчдоос өөрийн хамгийн сайн мэдэх 4-ийг нэрлэн бичнэ үү. /4 оноо/

.....
.....
.....

СУРГУУЛИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН КОМИСС

Материал зөссөн: Багш

БАТЛАВ
ЗАХИРАЛ М.АЮУШХОРЛОО

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН
11 ДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ НИЙГЭМ СУДЛАЛЫН СОНГОХ КИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024.06.07

Хугацаа 80 минут

В хувилбар

Хэрлэн сум

Нийт оноо: 100

Сонгох даалгавар 30, оноо 60

Задгай даалгавар 10, оноо 40

Анги:

Сурагчийн нэр:

Сэргээн санах түвшний даалгавар:

- Ядуу хүмүүс бодит хэрэгцээнээсээ бага эрүүл мэндийн үйлчилгээ авч байгаа нь:
1 - дүгээрт санхүүгийн боломж
2 - дугаарт ядуусын соёл
3 - дугаарт нийгмийн институтийн саад бэрхшээлтэй холбоотой хэмээн дүгнэсэн судлаач хэн бэ? /2 оноо/
A. Ө.Күүс B. Д.Датон C. Гилберт D. Калл
- Соёлын үйлдвэрлэл гэдэг ойлголт соёл судлалд хэдийгээс хэрэглэгдэж эхэлсэн бэ? /2 оноо/
A. 1970-аад оны үед B. 1980-аад оны үед C. 1990 оноос D. 1990 оны эхнээс
- Мөнгөний хумих бодлого аль нь вэ? /2 оноо/
A. Гүйлгээнээс мөнгө татах буюу мөнгөний нийлүүлэлтийг бууруулах бодлого
B. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлого
C. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлого
D. Гүйлгээнд мөнгө нэмж оруулах буюу мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бодлого
- "Аливаа зүйлийг хийж бүтээнэ гэдэг нь өчүүхэн ч атугай бусадтай чөлөөтэй хамтран ажиллана" гэж хэн үзсэн бэ? /2 оноо/
A. Р. Даредорьф B. Р.Путнам C. Г. Гегель D. М. Кинг
- Хууль, дүрэм журмыг зөрчсөн нийгэмд хор аюултай, хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагатай гэм буруйтай үйлдэл, эс үйлдлийг юу гэж нэрлэдэг вэ? /2 оноо/
A. эрх зүй B. эрх зүйн зөрчил C. гэмт хэргийн зөрчил D. гэмт хэргийн бус зөрчил
- Хэрэг үүсгэх өдрөөс хойш орон нутагт хэд хоногийн дотор шүүх нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах вэ? /2 оноо/
A. 7 хоног B. 14 хоног C. 21 хоног D. 30 хоног
- ОУХ-нд оролцогчдын хоорондын харилцааг зохицуулдаг хууль зүйн зарчим, хэм хэмжээний тогтолцоог юу гэж нэрлэдэг вэ? /2 оноо/
A. олон улсын харилцаа C. олон улсын эрх зүй
B. улс бус оролцогч D. гуравдагч хөршийн бодлого
- Олон улсын байгууллагын үйл ажиллагааны бүс нутгийн түвшинд аль нь хамаарах вэ? /2 оноо/
A. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн
B. Ази Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга
C. Аль Кайда бүлэглэл D. Евразийн эдийн засгийн холбоо

Ойлгох түвшний даалгавар:

- Энхбатын аав, ээж малчин харин Энхбат их сургуулийн захирлаар ажилладаг. Энэ нь нийгмийн шилжих хөдөлгөөний аль хэлбэрт хамаарах вэ? /2 оноо/
A. Бүлгийн шилжих хөдөлгөөн B. Үеийн хоорондын шилжих хөдөлгөөн
C. Үе дотоодын шилжих хөдөлгөөн D. Хэвтээ чиглэлийн шилжих хөдөлгөөн
- 1989 онд судлаач Мери Месенжер Девиес "Зурагт хүүхдэд сайн зүйл үү" гэдэг номондоо зурагтаар үзүүлдэг балмад явдлууд хүүхдүүдэд ямар нөлөө үзүүлдгийг анхааран судалжээ. Энд цочирдох, цагаатгах, мэдрэмжгүй болох гэсэн гурван янзын зөрчлийн тухай өгүүлжээ. Бага насны хүүхдүүдэд том тоглоом руу хүүхдүүд алх барин эвдэлж байгааг харуулсан кино үзүүлжээ. Дараа

нь яг кинонд үзүүлсэнтэй адил тоглоом бүхий өрөөнд хүүхдүүд юу хийхийг ажигласанд олон хүүхэд дэлгэцээр үзсэнтэй адил балмад авирласан байна. Энэ нь: /2 оноо/

А.Цочирдол В.Цагаатгал С.Мэдрэмжгүй D.Кибер орон зай

11. Сүүлийн үед манай улсын уул уурхайн компаниуд хөрөнгө оруулалт татах зорилгоор дэлхийн томоохон биржүүд дээр хувьцаагаа зарж эхэлсэн явдлыг хөрөнгө оруулалтын ямар хэлбэрээр тайлбарлаж болох вэ? /2 оноо/

А.Капиталын хөрөнгө оруулалт В.Шууд хөрөнгө оруулалт
С.Шууд бус хөрөнгө оруулалт
D.Портфелийн хөрөнгө оруулалт E.Татварын хөрөнгө оруулалт

12. Төрөөс “Засгийн газрын хөтөлбөр, төсөл” боловсруулж түүнийг хэрэгжүүлэхэд зориулж зардлаа ихэсгэж болно. Ингэж ажил эрхлэлт болон хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж улмаар нийт эрэлт нэмэгддэг гэвэл энэ нь: /2 оноо/

А.Төсвийн зарлагыг нэмэгдүүлэх бодлого
В.Төсвийн орлогыг бууруулах бодлого
С.Зээлийн хүүгийн бодлого
D.Татварын хэмжээг бууруулах бодлого

13. “Улс төрийн намуудыг бодлогын өрсөлдөөнд дуудаж төлөвшүүлдэг, жөндөрийн болон угсаатны бүлгийн төлөөлөл, оролцоог дэмждэг, олон намын тогтолцоо төлөвших нь сонгуулийн аль тогтолцооны шинжүүд вэ? /2 оноо/

А.Мажоритар тогтолцоо В.Пропорциональ тогтолцоо
С.Холимог тогтолцоо D. Харьцангуй олонх

14. Албан татвар төлөх, цэргийн алба хаших зэргээр материалын дэмжлэг үзүүлэх, хууль журмыг дагаж мөрдөх, төрийн албан ёсны мэдээлэл, бэлгэдлийг хүндэтгэн үзэх зэрэг нь улс төрийн тогтолцооны аль бүрэлдэхүүнд хамаарах вэ? /2 оноо/

А.Бодит дэмжлэг В.Оролцооны дэмжлэг С.Гадаад шаардлага D.Дотоод шаардлага

15. Тодорхойлолтуудаас аль нь хамгаалах үүрэг вэ? /2 оноо/

А. Тухайн эрхийг эдлэхэд ямар нэгэн саад учруулахгүй, зөрчихгүй байх үүрэг хүлээдэг

В. Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь сэргээх үүрэг хүлээдэг

С. Хүний эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн баталгааг бий болгох арга замыг авах үүрэг хүлээдэг

D. Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон хохирлыг арилгах бүтэц, тогтолцоог бий болгох боловсронгуй хууль тогтоомж батлах үүрэг хүлээдэг

16. Тухайн захиргааны байгууллагыг байгуулах, татан буулгах, албан тушаалтныг сонгох, томилох, захиргааны актыг хүчингүй болгох эрх бүхий субъектыг “шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан”гэдэг. Тэгвэл дүүргийн Засаг даргын шууд харьяалах дээд тушаалтан хэн бэ? /2 оноо/

А.Ерөнхий сайд В.Нийслэлийн Засаг дарга
С.Ерөнхийлөгч D.УИХ-ын дарга

17. ОУХ-ны бүрэн эрхт субъектүүд нь бүрэн эрхт улс, үндэстэн дамнасан корпорацууд, засгийн газрын байгууллагууд хувь хүмүүс байдаг. Энэ нь олон улсын онолын аль чиглэлд хамаарах вэ? /2 оноо/

А. Неореалист онол В. Неолиберал онол С.Реалист D. Либерал

18. Монгол дэлхийн 164 улстай дипломат харилцаатай байна. Тэгвэл 1990 онд аль улстай дипломат харилцаа тогтоосон бэ? /2 оноо/

А.Бүгд Найрамдах Солонгос улс В.Бүгд Найрамдах Турк улс
С. АНУ D. Канад улс

Хэрэглэх түвшний даалгавар:

19. Үүсгэсэн кодуудын давхцалаас шинэ код үүсгэнэ. Жишээ нь: Болд 1992 онд төрсөн өнөөдөр 32 настай. Энэ нь доорх өгөгдлийн алинд нь хамаарах вэ? /2 оноо /

А. Нээлттэй кодлолт В. Хаалттай кодлолт С. Категорчлол D. Харьцуулсан жишилт

20. Монгол улсын эдийн засаг 2011 онд 17.5, 2012 онд 12.3 хувиар эрчимтэй өсөж байна. Харин ядуурлын хамрах хүрээ 2011 онд 9.4, 2012 онд 2.4 хувиар буурчээ. Тухайн жилүүдэд эдийн засгийн өсөлт хоёр оронтой тоогоор эрчимтэй өсөж байсан ч өсөлтийн үр ашиг ядуурлыг дорвитойгоор буурахад нөлөө багатай байсны учир шалтгааныг аль дүгнэлт хамгийн оновчтой тайлбарласан байна вэ? /2 оноо /

А. Эдийн засгийн өсөлтийг дагаж, ядуурал буурсантай холбоотой.

В. Эдийн засаг өссөн ч, тэгш бус байдал өссөнтэй холбоотой.

С. Эдийн засгийн өсөлт ядуурлыг бууруулаагүй байна.

D. Эдийн засгийн өсөлттэй ядуурлын бууралт холбогдох албагүй.

21. Хүснэгтийн хоосон зайд тохирох өгөгдлүүдийг зөв байршуулна уу. /2 оноо/

Өгөгдлүүд: /1-Иргэдийн авьяасыг нээх, хөгжүүлэх боломжийг бий болгох; 2-Түүх, соёлын үнэт зүйлийг нийтийн хүртээл болгох; 3-Соёлын аялал жуулчлалын ач холбогдол/

Соёлын үйлдвэрлэлийн ач холбогдол	A
B	Бусдын соёлд хүндэтгэлтэй хандах
Ажлын байр нэмэгдэх	C

A. a3,b1,c2 B. a3,b2,c1 C. a2,b3,c1 D. a2,b1,c3

22. "Цахим орчинд "бүх юм" бий. Шинэхэн сонин сайхан мэдээ, дуулиан шуугиан, нийслэл, том хотуудын болон хөдөө орон нутгийн сонин сэтгүүл, дэлхий дахины хөрөнгийн биржүүд дээрх янз бүрийн хувьцааны ханшийн мэдээ, зээллэгийн хувь хэмжээ, тухайн долоо хоногийн буюу тухайн өдрийн валютын ханш, олон улсын нислэгийн хуваарь гэх мэт". Дээрх жишээнд тохирох өгөгдлийг олно уу. /2 оноо/

A. Соёлын даяаршил B. Соёлын орон зай C. Кибер орон зай D. Соёлын нэвчилт

23. Манай улсын ГШХО-ын 70,0 орчим хувийг уул уурхайн салбар дахь ГШХО эзэлдэг. Уул уурхайн салбар дахь ГШХО нь түүнийг оруулж ирж буй улсдаа эерэг үр дагавартай вэ? /2 оноо/

A. Байгаль орчинд сөргөөр нөлөөлж бэлчээрийн талбайг хомсдуулж уламжлалт МАА-н салбарын хөгжлийг саатуулагч хүчин зүйл болж байна

B. Гадаадын уул уурхайн компанид манай улсын олон мянган хүн ажил эрхэлж байна

C. Уул уурхайгаас хамаарсан эдийн засгийн өсөлт иргэдийн амьжиргаанд нөлөө үзүүлэхгүй байна

D. Ажилчдын цалин бусад орнуудтай харьцуулахад доогуур байгаа нь ажиллах хүчний мөлжлөгийн шинжтэй байна

24. БНХАУ-аас явуулсан хувийн хэвшлийн үйлдвэрлэлийн салбаруудыг дэмжих бодлогын дүнд 2018 онд цагаан будааг хамгийн доод үнээр худалдаж, Азийн зах зээлийг эзэлсэн ба улмаар 2019 онд цагаан будааны үнийг 15%-аар нэмсэн байна. Дээрх жишээ гадаад худалдааны онолын аль өгөгдөлд хамаарах вэ? /2 оноо/

A. Харьцангуй давуу тал B. Туйлын давуу тал

C. Гадаад худалдааны тэнцэл D. Демпинг худалдаа

25. Дараах бүдүүвчид өгсөн өгөгдлүүдийг зөв дараалалд оруулна уу. /2 оноо/

Өгөгдлүүд: /1-Гомдол хүлээн авах бүртгэх, 2-Гомдлын мөрөөр шалгалт хийх, 3- Гомдлыг шийдвэрлэх,

4- Гомдлыг шийдвэрлэх үйл явц/



A. a4,b1,c3,d2 B. a4,b1,c2,d3 C. a1,b2,c3,d4 D. a1,b2,c4,d3

26. МУ-ын шүүхийн тогтолгоог зөв тохируулна уу. /2 оноо/

1. Аймаг, нийслэлийн шүүх A. Анхан шатны шүүх

2. Улсын дээд шүүх B. Давж заалдах шүүх

3. Сум, сум дундын, дүүргийн шүүх C. Хяналтын шатны шүүх

A. a3,b1,c2 B. a3,b2,c1 C. a2,b3,c1 D. a2,b1,c3

27. Монгол улсын иргэн Батаа иргэний хувиар татвараа тогтмол төлдөг. Энэ нь /2 оноо /

A. Оролцооны дэмжлэг B. Бодит дэмжлэг B. Гадаад шаардлага Г. Дотоод шаардлага

28. Байгальд ээлтэй үйлдвэрлэлийг дэмжих шаардлага ёсоор УИХ-ын намрын чуулганаар үйлдвэрлэлийн бохирдлыг голын сав газар руу асгахыг хориглосон БОЯ-ны тушаал гарсан байна. Энэ нь улс төрийн ситемийн аль бүрдэл хэсэгт хамаарах вэ? /2 оноо/

A. Оролт B. Орчин C. Шийдвэр D. Дэмжлэг

29. Монгол улстай түншлэлийн харилцаатай улсуудыг харуулсан бүдүүвчийг гүйцээгээрэй. /2 оноо/

а)..... : АНУ, б)....., Герман, Турк

A. а-Стратегийн түншлэл, б-Япон

B. а-Иж бүрэн стратегийн түншлэл, б-БНХАУ

C. а-Стратегийн түншлэл, б-БНСУ

D. а-Иж бүрэн түншлэл, б-БНСУ,

30. Хатуу хүчний бодлогын жишээг олно уу./2оноо/

A. Монгол улс иргэдээ гадаадад визгүй зорчих 19 оронтой гэрээ байгуулсан.

B. Япон улс Монголд айлчлалаар 850 сая ам. Долларын хөнгөлттэй зээл олгосон.

C. Монгол улс АНУ-ын Мянганы сангын буцалтгүй тусламжийг авсан

D. Арабын нэгдсэн Эмират улс нь европ руу нефт, газрын тосны худалдаагаа хаав.

Задлан шинжлэх түвшний даалгавар:

31. Тохиолдлыг уншаад асуултын дагуу шинжлээрэй. /4 оноо/

Тохиолдол: Иргэн И 1978 онд Орхон аймагт Ш гэдэг ажилчин эмэгтэйн гэр бүлд төрсөн. Ээждээ тусалж, дүү нараа тэжээхийн тулд 5-р ангиасаа сургуулиасаа завсардсан. Оройгоор бүрэн дунд боловсрол эзэмшин ШУТИС-д элсэн суралцаж цахилгааны инженерээр төгссөн. Дарханы төмөрлөгийн үйлдвэрт инженерээр ажилладаг.

Асуулт: Тохиолдол байр суурийн хөдөлгөөний ямар чиглэлд хамаарах вэ? /2 оноо/

Асуулт. Босоо ба хэвтээ чиглэлийн байр суурийн хөдөлгөөний ижил ба ялгаатай талыг харьцуулна уу?

32. Хүснэгтийн хоосон зайд тохирох өгөгдлийг зөв байршуулна уу. /4 оноо/
Өгөгдөл: /1-Соёлын солилцоо; 2-Соёлын харилцан үйлчлэл; 3-Соёлын тулгалт; 4-Соёлын шок; 5-Соёлын хуулбарлан дуурайх; 6-Соёлын адилсал/

A.....	Нэг хэсэг хүн амын соёлын амьдрал нөгөө хэсгийнхтэй адилсан, өмнөх соёлын дадал хэвшлээсээ хавьгүй илүүд шүжү хүлээн зөвшөөрөх байдал
B.....	Бүтээсэн бүхнийг устгаж, хүнийг тэр зүйлээ дахин бүтээхгүй болтол нь айлган сүрдүүлэх явц. Ихэвчлэн цаг үеийн хүчирхэг гүрнүүдийн зүгээс бага буурай улс оронд хандсан үйлдэл юм.
C.....	Улс гүрнүүд өөр хоорондоо ололт дэвшлүүдээ бие биедээ солилцон хамтаараа хөгжих явц.
D.....	Улс үндэстэн угсаатны харилцан үйлчлэл. Энэхүү үйл явц хэтэрвэл соёлын олон янз байдал, оршин тогтнолд сөргөөр нөлөөлөх байдал үүсдэг.

33. Доорх хүснэгтэн мэдээллийг ашиглан 33,34-р асуултад хариулаарай.

Огноо	2012	2013	2014	2015	2016
Үзүүлэлт					
Аялал жуулчлалын салбарын нийт орлого, сая, ам.долл	286.5	263.2	253.8	277.0	312.8
ДНБ-д эзлэх хувь хэмжээ	2.3	2.1	2.11	5.3	5.6

Асуулт: Аялал жуулчлалын орлого 1%-иар өсөхөд түүний ДНБ-д эзлэх хэмжээ хэдэн хувиар өсөж байна вэ? /4 оноо/

Бодолт хийх:

34. Аялал жуулчлалын орлого болон түүний ДНБ-д эзлэх хувь хэмжээг графикаар илэрхийлээрэй. /4 оноо/

График:

35. Дараах тохиолдлыг уншаад 35,36 дугаар асуултад хариулаарай.
Тохиолдол 1: Бүртгэгдсэн гэмт хэрэг 2022 онд 35340 болж, өмнөх оноос 9911 (39.0%)-ээр өсжээ. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс өсөхөд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 7861 (57.7%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1688 (22.1%), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 305 (33.3%), хүний бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 138 (25.6%)- аар өссөн нь голлон нөлөөлжээ. .
Гэмт хэргийн гол шинжийг нэрлэнэ үү. /4 оноо/

36. Дээрх тоон мэдээллийг уншаад ямар дүгнэлт хийж болох вэ? /4 оноо/

37. Дараах баримтыг судлан 37, 38-р асуултад дүн шинжилгээ хийнэ үү.

Баримт1. 2004 оны УИХ-ын сонгуульд жижиггэсэн мажоритар буюу 1 тойрог - 1 мандат хэлбэрээр явагдсан сонгуульд сонгогчдын 48.8 хувийн саналыг авсан МАХН УИХ-д 36 суудалтай, харин 44.8 хувийн санал авсан Ардчилсан нам 36 суудалтай болжээ.

Баримт2. 2008 оны УИХ-ын сонгуульд томсгосон мажоритар буюу 1 тойрог олон мандат хэлбэрээр явагдсан сонгуульд сонгогчдын 43 хувийн саналыг авсан МАХН УИХ-д 45 суудалтай, харин 39.2 хувийн санал авсан Ардчилсан нам 28 суудалтай болжээ.

Баримт3. 2012 оны УИХ-ын сонгуульд томсгосон мажоритар 26 тойргоос 48 нэр дэвшигч сонгох сонгуульд сонгогчдын 33.5 хувийн саналыг авсан МАН 17 суудал авсан бол 34.2 хувийн саналыг авсан АН 25 суудал, 17.9 хувийн санал авсан МАХН 3 суудал авсан. Харин намын жагсаалтаар сонгогдох 28 нэр дэвшигчийг намууд авсан саналын хэмжээтэй дүйцэхүйц хэмжээгээр хувааж авжээ.

Энэ 3 баримт сонгуулийн ямар тогтолцооны онцлогийг харуулж байна вэ? /4 оноо/

38. Сонгогчдын саналыг их авсан ч парламентын суудал бага авч байгаа шалтгааныг тайлбарлана уу /4 оноо/

39. Дараах мэдээллийг уншаад 39,40-р асуултад хариулаарай

Мэдээлэл1. Монгол улс нь олон улсын харилцааны нэгэн оролцогч мөн. Монгол улс нь 20 орчим олон улсын байгууллагын гишүүн бөгөөд 10 орчим олон улсын байгууллагатай эрчимтэй хамтран ажилладаг. 2015 оны байдлаар Монголд Улс дэлхийн 181 оронтой дипломат харилцаатай. Гадаадын 31 оронд Монгол улсын Элчин сайдын яам болон гадаадын 8 оронд 11 Ерөнхий Консулын газрууд, 5 Консулын төлөөлөгч үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн үүнээс гадна Монгол улсын 75 Өргөмжит консул гадаад орнуудад үйл ажиллагаагаа явуулж байна. Улаанбаатарт гадаадын 23 орны Элчин сайдын яам, орон нутагт гадаадын 3 Ерөнхий консулын газар үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол улсын энгийн паспорттай иргэд дэлхийн 19 оронд визгүй зорчиж байгаа бөгөөд албан, дипломат паспорттой иргэд дэлхийн 45 оронд визгүй зорчиж байна.

Асуулт: Тоон өгөгдөлд дүн шинжилгээ хийж, гадаад бодлогын стратегийг тодорхойлно. /4 оноо/

40. Монгол улсын иргэдийн 19 оронд визгүй зорчдог гуравдагч хөршийн орнуудаас өөрийн хамгийн сайн мэдэх 4 орныг нэрлэн бичнэ үү. /4 оноо/

СУРГУУЛИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН КОМИСС

Материал зассан: Багш